

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын эрүүл мэндийн төвийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын хураангуй тайлан**

Аудитын код: ХӨА-2026/040/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Мөрөн сум

2026 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунтуяа

Утас: 99036832 Цахим хаяг: ariuntuyab@audit.gov.mn

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас: 99389208 Цахим хаяг: b_myadagmaa@yahoo.com

Аудитор Ц.Мөнхтуяа

Утас: 99382220 Цахим хаяг: Munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 01/166
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
РЭНЧИНЛХҮМБЭ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Х.ЧУЛУУНХҮҮ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Рэнчинлхүмбэ сумын Эрүүл мэндийн төв нь 2025 онд Эрүүл мэндийн даатгалын сангаас авах 305,286.3 мянган төгрөгийг санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 23,374.1 мянган төгрөгийн 10 алдаа, зөрчил илрүүлж, 21,811.2 мянган төгрөгийн 6 алдааг залруулж, 1,562.9 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өглөө.

Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Рэнчинлхүмбэ сумын Эрүүл мэндийн төвтэй байгуулсан анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах 2025 оны гэрээний биелэлтийг 83.7 хувьтай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А. ЭРДЭНЗБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	612,350,011.52	629,425,002.96
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	108,294,331.13	76,178,231.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	108,294,331.13	76,178,231.00
3121	Төгрөг	108,294,331.13	76,178,231.00
31211	Төрийн сангийн харилцах	108,294,331.13	76,178,231.00
33	АВЛАГА	290,748,808.95	305,286,316.85
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	290,748,808.95	305,286,316.85
35	БАРАА МАТЕРИАЛ	213,306,871.44	247,960,455.11
351	Түүхий эд материал	74,017,082.83	97,341,278.31
35130	Эм боох материал	74,017,082.83	97,341,278.31
354	Хангамжийн материал	139,289,788.61	150,619,176.80
35410	Бичиг хэргийн материал	4,856,110.00	6,129,250.00
35420	Аж ахуйн материал	100,999,406.74	101,052,559.38
35430	Сэлбэг хэрэгсэл	2,160,000.00	4,160,000.00
35440	Түлш, шатах тослох материал	14,176,050.00	15,000,000.00
35450	Барилгын засварын материал	00.00	9,639,000.00
35460	Хүнсний материал	8,033,837.55	5,573,983.10
35470	Бусад хангамжийн материал	9,064,384.32	9,064,384.32
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	477,291,131.45	472,028,460.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	477,291,131.45	472,028,460.00
392	Биет хөрөнгө	447,711,131.57	442,558,460.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	216,825,849.00	216,825,849.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-136,945,318.52	-150,184,212.44
39203	Авто-тээврийн хэрэгсэл	266,328,000.00	266,328,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-48,412,761.54	-100,122,772.55
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	424,119,367.39	539,994,067.39
39206	Хуримтлагдсан элэгдэл	-287,747,532.50	-346,016,785.94
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,290,950.43	52,930,950.43
39208	Хуримтлагдсан элэгдэл	-29,747,422.69	-37,196,635.73
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,709,179.00	6,709,179.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-6,709,179.00	-6,709,179.00
393	Биет бус хөрөнгө	29,579,999.88	29,469,999.84
39301	Програм хангамж	825,000.00	825,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-605,000.12	-715,000.16
39303	Бусад биет бус хөрөнгө	29,360,000.00	29,360,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	1,089,641,142.97	1,101,453,462.96
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	10,894,540.10	2,100,850.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,894,540.10	2,100,850.00
413	Өглөг	10,894,540.10	2,100,850.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	10,894,540.10	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	2,100,850.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,078,746,602.87	1,099,352,612.96
51	Засгийн газрын хувь оролцоо	1,078,746,602.87	1,099,352,612.96
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	269,328,439.00	269,328,439.00
51101	Өмч: - төрийн	269,328,439.00	269,328,439.00
512	Хуримтлагдсан үр дүн	708,717,946.07	729,323,956.16
51210	Өмнөх үеийн үр дүн	708,717,946.07	708,717,946.07
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	20,606,010.09
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	100,700,217.80	100,700,217.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,089,641,142.97	1,101,453,462.96

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,712,791,156.69	1,783,887,023.07
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	357,345,030.27	222,670,672.67
120	Нийтлэг татварын бус орлого	357,345,030.27	222,670,672.67
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	357,345,030.27	222,670,672.67
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	83,127,000.00	118,681,752.08
1200017	Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого-үндсэн хөрөнгө	241,350,060.00	76,377,000.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого-бараа материал	32,867,970.27	27,611,920.59
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,355,446,126.42	1,561,216,350.40
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	30,158,900.00	63,259,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	30,158,900.00	63,259,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,325,287,226.42	1,497,956,450.40
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,325,287,226.42	1,497,956,450.40
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,332,010,755.93	1,763,281,012.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,332,010,755.93	1,763,281,012.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,280,883,701.10	1,625,065,476.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	872,869,992.20	1,048,975,006.20
210101	Үндсэн цалин	528,850,836.63	639,440,832.71
210102	Нэмэгдэл	253,729,800.90	315,518,331.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,066,000.00	25,085,000.00
210104	Урамшуулал	66,223,354.67	68,930,842.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,621,950.66	119,610,240.03
210201	Тэтгэврийн даатгал	69,498,595.77	87,151,171.18
210202	Тэтгэмжийн даатгал	8,770,663.76	8,707,137.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,766,798.07	4,943,779.43
210204	Ажилгүйдлийн даатгал	3,554,227.71	3,629,536.93
210205	Эрүүл мэндийн даатгал	14,031,665.35	15,178,615.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,334,970.17	33,832,341.05
210301	Гэрэл, цахилгаан	4,925,845.17	6,728,341.05
210302	Түлш, халаалт	13,939,125.00	25,804,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,470,000.00	1,300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	70,197,772.18	90,424,510.15
210401	Бичиг хэрэг	2,355,225.00	13,169,890.00
210402	Тээвэр, шатахуун	39,291,035.00	47,807,660.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,420,000.00	2,832,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	978,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	23,067,288.18	22,030,347.36
210408	Бараа материал акталсны зардал	2,086,224.00	4,583,912.79
2105	Нормативт зардал	85,309,807.46	106,758,656.07
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	67,150,990.36	89,133,751.62
210502	Хоол, хүнс	18,158,817.10	17,624,904.45
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,416,500.00	49,547,100.00
210604	Урсгал засвар	6,416,500.00	49,547,100.00
2107	Томилолт, зочны зардал	6,303,400.00	6,394,800.00
210702	Дотоод албан томилолт	6,303,400.00	6,394,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,261,953.00	35,490,452.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,380,400.00	33,749,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	1,152,000.00

210803	Даатгалын үйлчилгээ	200,925.00	133,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	385,548.00	351,982.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	88,080.00	58,720.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	100,567,355.43	134,032,371.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,681,550.00	3,255,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	85,885,805.43	130,777,371.45
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,127,054.83	138,215,536.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,622,000.00	115,247,977.08
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	98,279,977.08
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	50,622,000.00	16,968,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	505,054.83	22,967,558.95
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	505,054.83	22,967,558.95
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	380,780,400.76	20,606,010.09
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,400,000.16	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,400,000.16	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-2,400,000.16	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	378,380,400.60	20,606,010.09

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,167,784,375.47	1,665,360,594.58
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	83,127,000.00	118,681,752.08
120	Нийтлэг татварын бус орлого	83,127,000.00	118,681,752.08
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	83,127,000.00	118,681,752.08
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	83,127,000.00	118,681,752.08
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,084,657,375.47	1,546,678,842.50
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	30,158,900.00	63,259,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	30,158,900.00	63,259,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,054,498,475.47	1,483,418,942.50
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,054,498,475.47	1,483,418,942.50
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,263,803,303.86	1,648,338,994.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,263,803,303.86	1,648,338,994.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,212,676,249.03	1,510,123,458.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	862,729,897.20	1,059,869,546.30
210101	Үндсэн цалин	509,473,665.67	652,197,737.93
210102	Нэмэгдэл	262,966,876.86	314,031,866.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,066,000.00	25,085,000.00
210104	Урамшуулал	66,223,354.67	68,554,941.78
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,867,505.56	119,610,240.03
210201	Тэтгэврийн даатгал	69,498,595.77	89,407,936.92
210202	Тэтгэмжийн даатгал	8,770,763.76	7,905,595.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,766,797.07	4,524,006.60
210204	Ажилгүйдлийн даатгал	3,554,227.71	3,393,936.66
210205	Эрүүл мэндийн даатгал	13,277,121.25	14,378,764.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол	27,075,845.17	37,028,341.05

	зардал		
210301	Гэрэл, цахилгаан	4,925,845.17	6,728,341.05
210302	Түлш, халаалт	20,680,000.00	29,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,470,000.00	1,300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	63,089,885.00	77,809,690.00
210401	Бичиг хэрэг	4,561,300.00	5,762,280.00
210402	Тээвэр, шатахуун	41,663,085.00	45,435,610.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,420,000.00	2,832,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,819,500.00	7,334,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,626,000.00	16,445,100.00
2105	Нормативт зардал	92,039,763.10	90,995,289.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	68,011,663.10	79,088,689.30
210502	Хоол, хүнс	19,828,100.00	11,906,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,200,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,867,500.00	67,813,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,750,000.00	9,387,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,350,000.00	00.00
210604	Урсгал засвар	23,767,500.00	58,425,500.00
2107	Томилолт, зочны зардал	6,303,400.00	6,394,800.00
210702	Дотоод албан томилолт	6,303,400.00	6,394,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,261,953.00	35,490,452.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,380,400.00	33,749,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	1,152,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,925.00	133,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	385,548.00	351,982.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	88,080.00	58,720.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,440,500.00	15,111,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,440,500.00	15,111,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,127,054.83	138,215,536.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,622,000.00	115,247,977.08
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	98,279,977.08
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	50,622,000.00	16,968,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	22,967,558.95
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	22,967,558.95
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	505,054.83	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-96,018,928.39	17,021,599.87
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	17,440,000.00	49,137,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,440,000.00	49,137,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	17,440,000.00	49,137,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	17,440,000.00	49,137,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-17,440,000.00	-49,137,700.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-113,458,928.39	-32,116,100.13
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	221,753,259.52	108,294,331.13
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	108,294,331.13	76,178,231.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /	
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	269,328,439.00	100,700,217.80	330,337,545.47	700,366,202.27	
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	378,380,400.60	378,380,400.60	
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	269,328,439.00	100,700,217.80	708,717,946.07	1,078,746,602.87	
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	20,606,010.09	20,606,010.09	
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	269,328,439.00	100,700,217.80	729,323,956.16	1,099,352,612.96	

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Улсын төсвийн гүйцэтгэл:

Данс	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/ төгрөгөөр /	
				зөрүү	хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,921,496,500.00	1,602,100,694.58	319,395,805.42	83.4
12	Татварын бус орлого	1,921,496,500.00	1,602,100,694.58	319,395,805.42	83.4
120	Нийтлэг татварын бус орлого	130,025,700.00	118,681,752.08	11,343,947.92	91.3
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	130,025,700.00	118,681,752.08	11,343,947.92	91.3
122	Тусламжийн орлого	1,791,470,800.00	1,483,418,942.50	308,051,857.50	82.8
122001	Хандив тусламж /дотоод/	1,791,470,800.00	1,483,418,942.50	308,051,857.50	82.8
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,029,790,800.00	1,634,216,794.71	395,574,005.29	80.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,029,790,800.00	1,634,216,794.71	395,574,005.29	80.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,902,986,800.00	1,518,968,817.63	384,017,982.37	79.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,228,483,000.00	1,059,869,546.30	168,613,453.70	86.3
210101	Үндсэн цалин	856,991,800.00	652,197,737.93	204,794,062.07	76.1
210102	Нэмэгдэл	262,247,400.00	314,031,866.59	-51,784,466.59	119.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	42,014,300.00	25,085,000.00	16,929,300.00	59.7
210104	Урамшуулал	67,229,500.00	68,554,941.78	-1,325,441.78	102.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	157,787,400.00	119,610,240.03	38,177,159.97	75.8
210201	Тэтгэврийн даатгал	113,429,500.00	89,407,936.92	24,021,563.08	78.8
210202	Тэтгэмжийн даатгал	11,089,500.00	7,905,595.79	3,183,904.21	71.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,544,700.00	4,524,006.60	1,020,693.40	81.6
210204	Ажилгүйдлийн даатгал	5,544,700.00	3,393,936.66	2,150,763.34	61.2
210205	Эрүүл мэндийн даатгал	22,179,000.00	14,378,764.06	7,800,235.94	64.8
2104	Хангамж, бараа материалын зардал	88,608,100.00	77,809,690.00	10,798,410.00	87.8
210401	Бичиг хэрэг	6,628,600.00	5,762,280.00	866,320.00	86.9
210402	Тээвэр, шатахуун	51,687,700.00	45,435,610.00	6,252,090.00	87.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,721,100.00	2,832,700.00	888,400.00	76.1
210405	Хог хаягдал зайлуулах,	7,820,700.00	7,334,000.00	486,700.00	93.8

	хортон мэрэгчдийн устгал, ариутгал				
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,750,000.00	16,445,100.00	2,304,900.00	87.7
2105	Нормативт зардал	133,511,900.00	90,995,289.30	42,516,610.70	68.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	99,067,500.00	79,088,689.30	19,978,810.70	79.8
210502	Хоол, хүнс	27,444,400.00	11,906,600.00	15,537,800.00	43.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	185,282,200.00	112,937,100.00	72,345,100.00	61.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	58,329,400.00	49,685,600.00	8,643,800.00	85.2
210602	Тавилга	21,925,100.00	8,090,000.00	13,835,100.00	36.9
210604	Урсгал засвар	90,583,200.00	55,161,500.00	35,421,700.00	60.9
2107	Томилолт, зочны зардал	23,078,000.00	6,394,800.00	16,683,200.00	27.7
210702	Дотоод албан томилолт	23,078,000.00	6,394,800.00	16,683,200.00	27.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	68,236,200.00	35,490,452.00	32,745,748.00	52.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	63,222,800.00	33,749,800.00	29,473,000.00	53.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	1,152,000.00	00.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.00	133,950.00	266,050.00	33.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	351,982.00	48,018.00	88.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	250,000.00	44,000.00	206,000.00	17.6
210807	Газрын төлбөр	180,000.00	58,720.00	121,280.00	32.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,000,000.00	15,861,700.00	2,138,300.00	88.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,000,000.00	15,861,700.00	2,138,300.00	88.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	126,804,000.00	115,247,977.08	11,556,022.92	90.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	126,804,000.00	115,247,977.08	11,556,022.92	90.9
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	109,836,000.00	98,279,977.08	11,556,022.92	89.5
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,968,000.00	16,968,000.00	00.00	100.0
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-108,294,300.00	-32,116,100.13		
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	108,294,300.00	32,116,100.13		
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	108,294,300.00	32,116,100.13		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	108,294,331.13		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	76,178,231.00		

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	40,533,700.00	40,292,341.05	241,358.95	99.40
12	Татварын бус орлого	40,533,700.00	40,292,341.05	241,358.95	99.40
122	Тусламжийн орлого	40,533,700.00	40,292,341.05	241,358.95	99.40
122005	Төсвөөс санхүүжих	40,533,700.00	40,292,341.05	241,358.95	99.40
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	40,533,700.00	40,292,341.05	241,358.95	99.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	40,533,700.00	40,292,341.05	241,358.95	99.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	40,533,700.00	40,292,341.05	241,358.95	99.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,033,700.00	37,028,341.05	5,358.95	99.99
210301	Гэрэл, цахилгаан	6,969,700.00	6,728,341.05	241,358.95	96.54
210302	Түлш, халаалт	28,764,000.00	29,000,000.00	(236,000.00)	100.82
210303	Цэвэр, бохир ус	1,300,000.00	1,300,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,500,000.00	3,264,000.00	236,000.00	93.26
210604	Урсгал засвар	3,500,000.00	3,264,000.00	236,000.00	93.26
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	-	-	-
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-	-
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-	-	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 23,374.1 мянган төгрөгийн 10 алдаа, зөрчил илэрснээс, 21,811.2 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 1,562.9 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгч, нийцлийн аудиттай холбоотой 2 зөрчилд зөрчил таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

3.1 Залруулсан алдаа

1. Жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэж ирүүлэхдээ тайлант оны худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийг гаргаж ирүүлээгүй, Сангийн сайдын 2025 оны А/З дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн маягтын дагуу тайланг бэлтгэж ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7 “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах;” заалттай нийцэхгүй “толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад нөхөж гаргасан.
2. Ашиглалтын шаардлага хангахгүй акталсан 4,583.9 мянган төгрөгийн бараа материалыг тайлант үеийн зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулсан.
3. Үндсэн хөрөнгийн элэгдлийг 5,518.1 мянган төгрөгөөр дутуу бодуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул элэгдлийг дахин бодуулж, залруулга хийсэн.
4. Нийгмийн эрүүл мэндийн зардлаас зарцуулсан 11,709.2 мянган төгрөгийн эм, хүнс, бичиг хэргийн зардлыг холбогдох зардалд нь бүртгээгүй, үр дүнгийн тайланд бусад зардлаар толилуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй “толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулгыг хийж, үнэн зөв толилуулсан

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 1,562.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 21,312.2 мянган төгрөгөөс бага байх тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.2. Албан шаардлага

1. Шилэн дансны цахим хуудсанд 11 төрлийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;”, гэж заасан заалттай нийцэхгүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байгаа нь “нийцсэн бөгөөд зохистой” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Иймд зөрчил таслан зогсоох тухай албан шаардлагыг хүргүүлсэн.
2. Рэнчинлхүмбэ сумын эрүүл мэндийн төв нь 2025 онд цахим дэлгүүрээс худалдан авах боломжтой 20,474.6 мянган төгрөгийн эмийг шууд худалдан авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 “Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна.” заалттай нийцэхгүй “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул зөрчил таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

3.3. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төлбөртэй үйлчилгээний орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус эрүүл мэндийн төв нь үйлчлүүлэгчид үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, жагсаалтыг гаргаж батлаагүй, шүдний эмчилгээний төлбөрийн орлогыг төвлөрүүлээгүй байгаа нь Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт нь улсын төсөв, эрүүл мэндийн даатгал, Засгийн газрын тусгай сан болон аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон, иргэний хандив, эрүүл мэндийн байгууллагын төлбөртэй тусламж, үйлчилгээ, бусад үйл ажиллагааны орлого, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ.”, Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Жагсаалт, журам батлах тухай” А/216 дугаар тушаал, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 49/А/118 тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлж олсон орлогыг зарцуулах үлгэрчилсэн журам”-тай нийцэхгүй, “ нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хууль журамд нийцүүлэн төлбөртэй тусламж үйлчилгээний жагсаалт, төлбөрийн хэмжээг баталж мөрдөх

2. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын шимтгэл, цалингийн бүлэг хооронд 1,391.2 мянган төгрөгийн гүйлгээг эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн нь Төсвийн

тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 заалтад заасан “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;” заалттай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг батлагдсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж байх

3. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1:

Тус байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн “тэг” үлдэгдэлтэй 147 нэр төрлийн 327,752.9 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;” заалт болон ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар бүлгийн 7.1 заалттай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тэг үлдэгдэлтэй хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнэлгээг шинэчлэн бүртгэлд тусгах

Илрүүлэлт 2:

Автотээврийн хэрэгслийн 171.7 мянган төгрөгийн татварыг нөхөн төлсөн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Татвар, төлбөр хураамжийг тухай бүрд нь төлж байх, улсын бүртгэлээс хасагдаагүй байгаа тээврийн хэрэгслийг хасуулах

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/			
							Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэн бүрэлдэхүүнээр, батлагдсан маягтаар бэлтгээгүй.	1	-	1	-			1	-		
НЭМ-ийн зардлаас зарцуулсан эм, хүнс, бичиг хэргийн зардлыг холбогдох зардалд нь бүртгээгүй, бусад зардлаар бүртгэсэн	1	11,709.2			1	11,709.2	1	11,709.2		
Акталсан бараа материалыг тайлант үеийн зардлаар бүртгэсэн	1	4,583.9			1	4,583.9	1	4,583.9		

Үндсэн хөрөнгийн элэгдлийг дутуу бодуулсан.	1	5,518.1			1	5,518.1	1	5,518.1		
Дүн	4	21,811.2	1	-	3	21,811.2	4	21,811.2		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн.	1	1,391.2					1	1,391.2
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн "0" үлдэгдэлтэй хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнэлгээг шинэчлээгүй	1	-					1	-
Төлбөртэй үйлчилгээний жагсаалт, төлбөрийн хэмжээг тогтоогоогүйгээс орлого төвлөрүүлээгүй	1	-					1	-
Тээврийн хэрэгслийн татварыг нөхөн төлсөн	1	171.7					1	171.7
Дүн	4	1,562.9					4	1,562.9

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны цахим хуудсанд 11 нэр төрлийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1	-			1	-		
Цахим дэлгүүрээс худалдан авах боломжтой эмийг шууд худалдаж авсан.	1	-			1	-		
Дүн	2	-			2	-		

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			